

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЦЭЦЭГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/62/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗД</i>	<i>Засаг дарга</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр8
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	11
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр 11
2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр12
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа: Аудитын явцад үндсэн хөрөнгийн ангилал, элэгдлийн тооцоолол, үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой 154476.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн болно.	16
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 5914.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	16
1. Өр төлбөртэй холбоотой асуудал	17
2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал	17
3. Татвар нийгмийн даатгалтай холбоотой асуудал	17
4. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал	17
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	18

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цэцэг сум, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЦЭЦЭГ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ ЭМЧ Н.СОЛОНГО ТАНАА

2021.02.25 № 4/НН
таний _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, эмч ажилчдын ёс зүйн асуудал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд өр төлбөр үүсгэсэн, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв хөтлөөгүй, татвар, нийгмийн даатгалын тооцоолол зөрүүтэй, худалдан авалтуудыг И баримтаар бүрэн баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг эрх зүйн акттай нийцэхгүй, "үнэн зөв байх", "хэмжилт", "бодитой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,888,427.78</u>	<u>23,410,088.78</u>
33	АВЛАГА	903,011.78	254,205.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	433,424.78	145,589.28
335	Бусад авлага	469,587.00	108,616.00
3351	Байгууллагаас авах авлага	469,587.00	108,616.00
34	УРЬДЧИЛГАА	300,000.00	300,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	300,000.00	300,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	300,000.00	300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,685,416.00	22,855,883.50
351	Түүхий эд материал	3,699,894.00	5,434,691.50
35110	Тусгай зориулалттай материал	271,200.00	271,200.00
35130	Эм боох материал	3,428,694.00	5,163,491.50
354	Хангамжийн материал	3,240,519.00	4,121,189.00
35420	Аж ахуйн материал	2,175,200.00	2,958,200.00
35460	Хүнсний материал	1,065,319.00	1,162,989.00
35600	Мал амьтад	3,745,003.00	13,300,003.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>600,113,149.84</u>	<u>571,292,000.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	600,113,149.84	571,292,000.92
392	Биет хөрөнгө	587,850,149.84	559,048,042.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	512,671,031.59	512,671,031.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,987,746.69)	(31,236,714.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,583,656.00	37,847,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,837,740.55)	(9,256,022.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110,091,987.00	121,793,987.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,432,266.61)	(87,475,920.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,634,919.00	27,654,919.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,873,689.90)	(12,950,459.11)
393	Биет бус хөрөнгө	12,263,000.00	12,243,958.34
39301	Програм хангамж	1,007,000.00	1,007,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(569,041.66)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,806,000.00	11,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>612,001,577.62</u>	<u>594,702,089.70</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,095,158.00</u>	<u>5,914,060.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,095,158.00	5,914,060.43
413	Өглөг	2,095,158.00	5,914,060.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	502,151.00	4,380,702.03
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,572,966.00	1,513,417.40
4136	Бусад өглөг	20,041.00	19,941.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20,041.00	19,941.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>609,906,419.62</u>	<u>588,788,029.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	609,906,419.62	588,788,029.27

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	129,079,912.00	129,079,912.00
51101	Өмч: - төрийн	129,079,912.00	129,079,912.00
512	Хуримтлагдсан үр дүн	123,471,901.42	102,353,511.07
51210	Өмнөх үеийн үр дүн	123,471,901.42	123,471,901.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	(21,118,390.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,354,606.20	357,354,606.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>612,001,577.62</u>	<u>594,702,089.70</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	553,357,803.00	479,272,705.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,961,473.00	46,662,395.00
120	Нийтлэг татварын бус орлого	182,961,473.00	46,662,395.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	182,961,473.00	46,662,395.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	15,800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	182,961,473.00	30,862,395.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,396,330.00	432,610,310.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,125,500.00	353,549,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,125,500.00	353,549,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,334,180.00	27,180,790.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	338,800.00	18,973,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,995,380.00	806,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,814,400.00	21,039,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,814,400.00	21,039,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,122,250.00	30,840,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,122,250.00	30,840,220.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	391,002,349.17	485,494,932.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,002,349.17	485,494,932.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,972,049.45	484,338,372.55

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,529,809.00	276,989,692.00
210101	Үндсэн цалин	229,282,809.00	254,805,601.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,247,000.00	5,087,000.00
210104	Урамшуулал	-	17,097,091.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,845,826.17	35,702,239.53
210201	Тэтгэврийн даатгал	20,464,633.81	24,622,651.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,345,298.09	2,769,896.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,876,238.46	2,215,917.55
210204	Ажилгүйдлийн даатгал	469,059.63	553,979.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,690,596.18	5,539,793.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,146,929.00	19,096,087.40
210301	Гэрэл, цахилгаан	1,426,729.00	2,275,587.40
210302	Түлш, халаалт	16,274,100.00	16,274,100.00
210303	Цэвэр, бохир ус	446,100.00	546,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,532,180.00	35,285,400.00
210401	Бичиг хэрэг	2,553,150.00	1,746,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,841,360.00	28,471,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,147,680.00	3,067,300.00
2105	Нормативт зардал	42,302,880.00	66,462,967.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,798,724.00	52,525,817.50
210502	Хоол, хүнс	8,541,156.00	10,437,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	963,000.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,123,200.00	2,306,200.00
210604	Урсгал засвар	2,123,200.00	2,306,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	945,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,103,000.00	4,222,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	982,000.00	3,175,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	397,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,088,225.28	43,328,586.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,726,630.00	4,936,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,361,595.28	38,391,986.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,299.72	1,156,560.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,156,560.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,156,560.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	162,355,453.83	(6,222,227.55)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	14,896,162.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	11,151,162.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	3,745,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(14,896,162.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	162,355,453.83	(21,118,390.35)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	370,396,330.00	435,110,310.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,500,000.00
120009	Бусад орлого	-	2,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	370,396,330.00	432,610,310.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,125,500.00	353,549,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,125,500.00	353,549,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,334,180.00	27,180,790.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	338,800.00	18,973,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,995,380.00	806,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,814,400.00	21,039,500.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,814,400.00	21,039,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,122,250.00	30,840,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,122,250.00	30,840,220.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	368,396,330.00	435,110,310.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,396,330.00	435,110,310.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,366,030.28	433,953,750.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,094,551.00	275,768,620.00
210101	Үндсэн цалин	214,046,989.00	206,079,856.98
210102	Нэмэгдэл	4,535,846.00	49,120,755.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,452,000.00	4,844,049.00
210104	Урамшуулал	11,059,716.00	15,723,959.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,808,900.00	35,846,400.00
210201	Тэтгэврийн даатгал	19,788,400.00	25,225,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,106,800.00	2,655,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,843,800.00	2,124,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,300.00	531,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,873,600.00	5,310,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,507,900.00	18,733,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,787,700.00	1,912,800.00
210302	Түлш, халаалт	16,274,100.00	16,274,100.00
210303	Цэвэр, бохир ус	446,100.00	546,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,516,090.00	33,271,500.00
210401	Бичиг хэрэг	2,485,350.00	2,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,613,060.00	26,471,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,889,380.00	2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	528,300.00	
2105	Нормативт зардал	39,474,321.00	47,716,930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,878,581.00	35,716,930.00
210502	Хоол, хүнс	8,632,740.00	8,500,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	963,000.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,306,200.00	5,606,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	3,300,000.00
210604	Урсгал засвар	2,306,200.00	2,306,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	945,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,089,818.28	10,063,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,668,818.28	9,008,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,268,250.00	6,002,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,268,250.00	6,002,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,299.72	1,156,560.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,299.72	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,299.72	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,156,560.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,156,560.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,000,000.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,000,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,000,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.00	
223001	Бусад хөрөнгө	2,000,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,000,000.00)	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	123,471,901.42	609,906,419.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	123,471,901.42	609,906,419.62
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	123,471,901.42	609,906,419.62
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	123,471,901.42	609,906,419.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	123,471,901.42	609,906,419.62
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,118,390.35)	(21,118,390.35)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	102,353,511.07	588,788,029.27

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	405440200.00	404523500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405440200.00	404523500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404940200.00	404523500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265529300.00	265529300.00
210101	Үндсэн цалин	177291300.00	199079856.98
210102	Нэмэгдэл	64965200.00	45881435.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5808000.00	4844049.00
210104	Урамшуулал	17464800.00	15723959.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35846400.00	35846400.00
210201	Тэтгэврийн даатгал	25225200.00	25225200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2655300.00	2655300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2124200.00	2124200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	531100.00	531100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5310600.00	5310600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18733300.00	18733300.00
210301	Гэрэл, цахилгаан	1912800.00	1912800.00
210302	Түлш, халаалт	16274100.00	16274100.00
210303	Цэвэр, бохир ус	546400.00	546400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33271500.00	33271500.00
210401	Бичиг хэрэг	2300000.00	2300000.00
210402	Тээвэр, шатахуун	26471500.00	26471500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	30,251,500.00	29,834,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,251,500.00	17,834,800.00
210502	Хоол, хүнс	8,500,000.00	8,500,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,606,200.00	5,606,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,300,000.00	3,300,000.00
210604	Урсгал засвар	2,306,200.00	2,306,200.00
2107	Томилолт, зочны зардал	945,000.00	945,000.00
210702	Дотоод албан томилолт	945,000.00	945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,755,000.00	8,755,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,700,000.00	7,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,002,000.00	6,002,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,002,000.00	6,002,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,879,720.00	404,523,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	352,643,780.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	352,643,780.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,039,500.00	21,039,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	21,039,500.00	21,039,500.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,840,220.00	30,840,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,840,220.00	30,840,220.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,430,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,430,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,430,250.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,239,320.00
210101	Үндсэн цалин	7,000,000.00
210102	Нэмэгдэл	3,239,320.00
2105	Нормативт зардал	17,882,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,882,130.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,308,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,308,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,430,250.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,430,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,723,310.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3306,940.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд аймгийн Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч эмч Н.Солонго танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд өр төлбөр, бараа материал, татвар, нийгмийн даатгал, анхан шатны баримт бүрдүүлэлт, үндсэн хөрөнгийн ангиллын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Н.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сумынхаа ард иргэдэд мэргэжлийн өндөр түвшинд тэгш хүртээмжтэй, шуурхай, чанартай үзүүлнэ гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ховд аймгийн Цэцэг сумын эрүүл мэндийн төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗД-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 391002.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3910.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 500391.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5003.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд аймгийн Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17299.5 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	903.0	254.2	648.8	-68%
Бараа материал	10685.4	22855.8	12170.5	114%
Үндсэн хөрөнгө	600113.1	571292.0	28821.1	-5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	612001.6	594702.1	17299.5	-3%
Өр төлбөр	2095.2	5914.1	3818.9	182%
Цэвэр хөрөнгө, өмч	609606.4	588788.0	21118.4	-3%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	612001.6	594702.1	17299.5	-3%

Авлага дансы үлдэгдэл 254.2 мянган төгрөг болж 648.8 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагчидтай холбоотой авлага, болон харилцагч байгууллагаас авах авлага нийтдээ 794.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22855.8 мянган төгрөг болж 12170.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд малын нас дэвшлийг тооцон бүртгэсэн 9555.0 мянган төгрөгийн өсөлт, аж ахуйн материалын болон эм боох материалын өсөлттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 600113.1 мянган төгрөг, оны эцэст 571292.0 мянган төгрөг болж 28821.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 17422.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан, урсгал зардлаас 3300.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүртгэн авсан, мөн 11151.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй фургон авто машиныг холбогдох шийдвэрийн дагуу сургуульд

шилжүүлсэн тайлант үеийн элэгдлийн зардал 38391.9 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант үед үр дүнгийн тайланд нийт 479272.7 мянган төгрөгийн орлого, нийт 500931.1 мянган төгрөгийн зардал, гарз тайлагнасан нь хуримтлагдсан үр дүн дансыг 21118.4 мянган төгрөгөөр бууруулж 102353.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 74085.1 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар буурсан байна. Энэ үзүүлэлт нь 31424.3 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн, үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан зүйлсээс хүлээн зөвшөөрсөн орлого 152099.1 мянган төгрөгөөр буурсан болон нэмэлт дансаар төвлөрсөн орлого 20846.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 98237.6 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 48316.3 мянган төгрөг буюу 20 хувь, тогтмол зардал 949.1 мянган төгрөг буюу 5 хувиар, бараа ажил үйлчилгээний зардал 5753.2 мянган төгрөг буюу 19 хувиар, нормативт зардал 24160.1 мянган төгрөг буюу 57 хувиар тус тус өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 430807.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 430807.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сард Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны төсвийг 401203.9 мянган төгрөгөөр баталжээ. 2020 оны 09-р сард ИТХ-аар төсөвт тодотгол 405440.2 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 405440.2 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 21039.5 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 353549.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 30850.9 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 353549.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 30840.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 21039.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 405429.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, урсгал үйл ажиллагаанд 404523.5 мянган төгрөгийг зарцуулж 906.0 мянган төгрөгийг холбогдох төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404523.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. зардлын ангиллаар авч үзэхэд төсвөөс хэтэрсэн зардал байхгүй бөгөөд бараа үйлчилгээний бусад зардлаас 16.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 906.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	Хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	189.3
80302	Нийгмийн эрүүл мэнд	416.7
80802	Тэтгэмж урамшуулал	300.0
	ДҮН	906.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дутагдаж байгаа зардалд 18751.4 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ЭМГ-аас, 7400.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, туслах үйл ажиллагаанаас 2500.0 мянган төгрөг, сорьц тээвэрлэлт болон хогны хаягдлын төлбөр 1029.3 мянган төгрөг нийт 29680.7 мянган төгрөг төвлөрүүлж, 29430.2 мянган төгрөгийг холбогдох үйл ажиллагаанд зарцуулж, 250.1 мянган төгрөгийг холбогдох төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг 80 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 160390.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 154476.0 мянган төгрөгийн залруулга хийгдэж, алдаа зөрчлийг арилгах, 5914.1 мянган төгрөгийн давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитын явцад үндсэн хөрөнгийн ангилал, элэгдлийн тооцоолол, үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой 154476.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 5914.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар сумын засаг даргын тамгын газрын хэрэглэсэн шатахууны үнэ 2000.0 мянган төгрөгийг нэмэлт дансанд төвлөрсөн тахлын голомтод ажиллах зардлаас Хөрс ХХК-д төлсөн бөгөөд үүний шатахууны тооцоо, замын хуудсыг хянаж үзэх нь зүйтэй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайланд бэлтгэн нийлүүлэгчид өгөх эмний үнэ 1533.3 мянган төгрөг, ХХОАТ-тай холбоотой 4380.7 мянган төгрөгийн нийт 5914.1 мянган төгрөгийн өглөг бүртгээсэн байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8. төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөн ажиллаж, төсвийн төлөвлөлтийг сар, улирлаар зөв төлөвлөж, холбогдох тооцоог тухай бүр бодож авлага, өглөг үүсгэхгүй ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Тайланд үеийн эмийн зарцуулалтыг журналаас хянан үзэхэд өдөр бүр тооцсон эмийн захиастай таарахгүй бөөн дүнгээр зарлагдсан, мөн шатахууныг тухай бүр орлогод аваагүй, жолоочийн тооцоог хянаж бодоогүй, шатахууны зарцуулалтыг бөөн дүнгээр зарлагдсан байна.
- 2.2. Эрсдэл: Дотоод хяналт хэрэгжихгүй байх, бараа материалын хяналт сулрах, төсвийн үргүй зардал нэмэгдэх
- 2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” 14.3.3-д “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын хавсралт 6.3.1-д “Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, бараа материалын ажил гүйлгээг гарсан тухай бүрд үнэн зөв бүртгэх
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Татвар нийгмийн даатгалтай холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгасан цалингийн зардал нь татварын тайлан ТТ-11-д тусгасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлоготой зөрүүтэй илэрхийлэгдсэн, мөн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцохдоо тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчаас илүү хувиар суутгасан зөрчил илэрлээ.
- 3.2. Эрсдэл: Хууль, тогтоомж зөрчих, дотоод хяналт сулрах
- 3.3. Өгсөн зөвлөмж: ХХОАТ тухай хуулийн 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүг тодорхой болгон тооцож залруулах
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

- 4.1. Илрүүлэлт: Тайлант онд худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

- 4.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх
- 4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах
- 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/62/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өр төлбөр үүсгэсэн	5914.1	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, Нягтлан бодогч	Н.Солонго Б.Мөнх-Эрдэнэ
2	Бараа материалын бөөн дүнгээр зарлагдсан	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, Нягтлан бодогч	Н.Солонго Б.Мөнх-Эрдэнэ
3	Татвар нийгмийн даатгал зөрүүтэй илэрхийлэгдсэн	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, Нягтлан бодогч	Н.Солонго Б.Мөнх-Эрдэнэ
4	Худалдан авалтуудыг И баримтаар баталгаажуулаагүй	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч эмч, Нягтлан бодогч	Н.Солонго Б.Мөнх-Эрдэнэ
ДҮН		5914.1			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР